

# ЭЦЭГ ЭХИЙН ХҮМҮҮЖҮҮЛЭХ АРГА БАРИЛ БА ХҮҮХДИЙН ДЭЛГЭЦИЙН ДОНТОЛТЫН ХАМААРЛЫГ СУДАЛСАН НЬ

**А. Анударь**  
Бакалавр оюутан

**Монгол улсын их сургууль**  
**Шинжлэх ухааны сургууль**

*aanudar4@gmail.com*

**Х. Номин**  
Бакалавр оюутан

**Монгол улсын их сургууль**  
**Шинжлэх ухааны сургууль**

**Хураангуй:** “Өсвөр нас” нь хүүхдийн хувьд маш чухал шилжилтийн үе шат юм. (өөрийн үнэ цэнэ бүрэлдэн бий болох, бусадтай харилцах хаарилцаа үнэт зүйл дээр тулгуурлан өөрчлөгдөх гм). Хүүхэд өөрийгөө илүү сайн таньж мэдэн зан байдал нь жинхэнэ утгаар бэхжин бий болоход хүүхдийн эцэг эх хамгийн том байр суурийг эзэлж байдаг. (Pederson & Reynolds, 1998). Эцэг эхчүүдийн хүүхдэд үзүүлэх нөлөөлөл чухал байдаг учраас тэд хүүхэддээ зөв үлгэр дуурайлал үзүүлэх, тэр дундаа интернет хэрэглээг зөв зохистой хэрхэн хэрэглэх, хүүхэдтэйгээ харилцах холбоо харилцаа бат бөх байх зэрэг нь хүүхдийн цахим хэрэглээнд донтох эрсдлээс урьдчилан сэргийлж байдаг(Li et al., 2022). Эцэг эхчүүдийн хүүхэдтэйгээ хэрхэн харьцаж буй байдал (эцэг эхийн нь хүүхэдтэйгээ дотно эсэх, эцэг эх хүүхдийн хооронд харилцаа үл ойшоосон хэв маягтай гэх мэт) нь хүүхдэд сэтгэл зүйн хувьд том нөлөөг үзүүлдэг байна. Судалгааны эх сурвалж, үндэслэл дээр тулгуурлан эцэг эхийн хүүхдээ хүмүүжүүлэх арга барил нь хүүхдийн интернет тоглоомд донтох, дэлгэцийн хамаарал ямар түвшинд байгааг олж тогтоохын тулд хүүхдүүдээс (ахлах ангийн сурагчид) Кимберли Ян боловсруулсан “Интернетийн дон бий эсэхийг үнэлэх асуулга” болон эцэг эхийн хүмүүжүүлэх арга барилыг (parenting style questionnaire) хүүхдийн итгэл үнэмшлээр тогтоон судалгааг явууллаа. Судалгааны үр дүнд эцэг эх нь хүүхэдтэйгээ захирангуй хэв маяг (authorition), болон үйл ойшоох (lack of control) хэлбэрээр харьцдаг эцэг эхийн хүүхдийн цахим хэрэглээний хамаарал хайрлах хэлбэрээр харьцдаг эцэг эхчүүдийн хүүхдүүдтэй харьцуулахад харьцангуй өндөр хувийг эзэлж байсан.

**Түлхүүр үг:** Хүмүүжүүлэх арга барил, интернет донтолт, хүүхэд, өсвөр нас

## УДИРТГАЛ

Орчин үеийн технологийн эрин үед хүүхэд, өсвөр насныхны өдөр тутмын амьдралд дэлгэцийн хэрэглээ салшгүй нэг хэсэг болж байна. Ухаалаг төхөөрөмж, цахим орчинд өнгөрүүлэх цаг

хэтрүүлснээр хүүхдүүдийн сэтгэл зүй, зан байдал, нийгмийн харилцаанд сөрөг үр дагавар үүсгэж болохыг олон улсын судалгаанууд харуулж байна (Li et al., 2022; Setiawati et al., 2021). Дэлгэцийн

донтолт нь интернетэд хэт их цаг зарцуулах, өөрийн амьдралын бусад чухал хэсгүүдийг үл тоомсорлох, нийгмээс тусгаарлагдах, сэтгэл гутралд өртөх зэрэг байдаг (Ko et al., 2005). Эцэг эхчүүд хүүхдийнхээ амьдралд анхаарал тавих, чиглүүлэх, үлгэрлэх үүрэгтэй гол хүмүүсийн нэг бөгөөд тэдний хүмүүжлийн арга барил нь хүүхдийн зан төлөв, сэтгэл зүйд шууд нөлөөлдөг. Baumrind (1967)-ийн онолын дагуу эцэг эхийн хүмүүжлийн 3 үндсэн хэв маяг болох хайрлах-хүндэтгэх (authoritative), захирангуй (authoritarian), үл хайхрах (neglectful) арга барилууд нь хүүхдийн хандлага, амьдралын хэв маяг, тэр дундаа цахим хэрэглээнд хэрхэн хандахыг тодорхойлоход чухал үүрэг гүйцэтгэдэг. Тодруулбал;

1. Хайрлах, хүндэтгэх (Authoritative): Хүүхдийг дэмжих, ойлгох, өөрийн хүлээлт, шаардлагыг тайлбарлах замаар харилцдаг. Энэ арга барил нь хүүхдийн өөрийгөө хянах чадвар, нийгмийн харилцааны эерэг хөгжилд түлхэц болдог (Baumrind, 1991).

2. Захирангуй (Authoritarian): Хүүхдэд өндөр шаардлага тавьдаг, гэхдээ түүнийг хангалттай дэмжихгүй. Энэ нь хүүхдийн зожигрох, бусдад захирагдах байдал, сэтгэл гутралын эрсдэлийг нэмэгдүүлдэг (Baumrind, 1967).

3. Үл хайхрах (Neglectful): Хүүхдийн хэрэгцээ, зан байдалд үл тоомсорлосон байдлаар ханддаг. Энэ арга барил нь хүүхдийн сэтгэл зүйн болон нийгмийн хөгжлийн сөрөг үр дагавартай холбоотой (Maccoby & Martin, 1983).

### ҮНДСЭН ХЭСЭГ

Bandura (1977)-ийн нийгмийн суралцах онолоор хүүхэд эцэг эхийн зан үйлийг ажиглаж, түүнийг дуурайж суралцдаг. Энэ нь цахим хэрэглээнд хэрхэн хандах хандлага дээр ч илэрдэг. Хэрэв эцэг эх өөрсдөө хэт их дэлгэц ашигладаг бол хүүхэд үүнийг хүлээн зөвшөөрөгдсөн зан төлөв гэж ойлгодог (Li et al., 2022).

Харин эцэг эх хүүхдийн интернетийн хэрэглээг зохицуулж, хяналт тавьж, хэрэглээний зөв дадлыг үлгэрлэж чадвал, хүүхдийн хэтрүүлэн ашиглах магадлал буурдаг (Setiawati et al., 2021).

Jessor (1991)-ийн асуудалтай зан үйлийн онолоор өсвөр насныхны асуудалтай зан авир нь орчинтойгоо шууд хамааралтай. Дэлгэцийн донтолт нь хүүхдийн өөрийгөө удирдах чадвар, амьдралын зөв дадал зуршилгүй байдалтай холбоотой. Судалгаагаар, эцэг эхийн үл хайхрах болон захирангуй арга барил нь хүүхдийн цахим хэрэглээний эрсдэлтэй хандлагыг

нэмэгдүүлдэг болох нь батлагдсан (Sung Ah Chung et al., 2023).

Bowen (1966)-ийн гэр бүлийн системийн онолоор гэр бүлийн харилцааны чанар нь хүүхдийн сэтгэл зүйд шууд нөлөөтэй. Эцэг эх, хүүхдийн хоорондын харилцааны дутагдалтай байдал нь хүүхдийг цахим орчинд тайвшрал, анхаарал, хүлээн зөвшөөрлийг хайхад хүргэдэг (Ko et al., 2005). Энэ нь дэлгэцийн донтолтын үндэс болж өгдөг.

Судалгаагаар, хайрлах, хүндэтгэх арга барил нь хүүхдийн өөрийгөө хянах, хариуцлагатай байх чадварыг дэмжиж, дэлгэцийн донтолтоос сэргийлэхэд эерэг нөлөө үзүүлдэг. Харин захирангуй болон үл хайхрах арга барил нь хүүхдийн интернетийн хэрэглээний хэт хамаарлыг нэмэгдүүлдэг болохыг тогтоосон (Di et al., 2019). Тиймээс энэхүү судалгаа нь эцэг эхийн хүмүүжлийн арга барил болон өсвөр насныхны дэлгэцийн донтолтын хоорондын хамаарлыг нарийвчлан судалж, асуудлыг шийдвэрлэх боломжит арга замыг тодорхойлоход чухал ач холбогдолтой юм.

### **Судалгааны зорилго, зорилтууд:**

**Зорилго:** Эцэг эхийн хүүхдээ хүмүүжүүлэх арга барил нь хүүхдийн сэтгэл зүй тэр дундаа интернет донтолт үүсгэх хүчин зүйл

болох эсэхийг олж мэдэх зорилготой.

### **Зорилт:**

1. Эцэг эхийн хүүхдээ хүмүүжүүлэх арга барил нь хүүхдийн интернет донтолтод нөлөөлдөг талаарх судалгааны ажлуудад дүн шинжилгээ хийх
2. Эцэг эхийн хүмүүжлийн арга барил ба дэлгэцийн донтолтын хоорондын хамаарлыг тодорхойлох.
3. Аль хүмүүжлийн хэв маяг дэлгэцийн донтолтод илүү хүчтэй нөлөөлж байгааг тодруулах.
4. Судалгааны үр дүнг эцэг эх, сурган хүмүүжүүлэгчдэд зориулсан зөвлөмж боловсруулахад ашиглах.

**Судалгааны таамаглал:** Эцэг эхийн хүмүүжүүлэх арга барил нь хүүхдийн интернет хэрэглээнд нөлөөлнө.

### **АРГА ЗҮЙ**

#### *2.1. Судалгааны түүвэр*

Нийт судалгаанд 234 (9-12) ахлах ангийн сурагчид хамрагдсан. (68 эрэгтэй, 127 эмэгтэй). 3 өөр ЕБС-ийн сурагчдаас судалгаа авах таниулсан хуудас өгөн, зөвшөөрөл авч судалгааг явуулсан. (Дархан-Уул аймгийн “Од цогцолбор” сургууль, Улсын тэргүүний “48-р сургууль”, НЕБ-ийн 104-р сургууль). Судалгаанд 234

оролцогч хамрагдсанаас 39 оролцогч 2 ба түүнээсдээш асуултыг үлдээж илгээн 195 ахлах ангийн сурагчдын судалгааны үр дүнтэй танилцан боловсруулсан. Нийт судалгаанд оролцогчдын 34.9% нь эрэгтэй сурагчид, 65.1% нь эмэгтэй сурагчид байна. Хүйсийн хувьд интернетийн хэрэглээг хэрэглэх дундаж оноо нь эмэгтэй сурагчдын хувьд 55.44, эрэгтэй сурагчдын интернетийг хэрэглэх дундаж оноо нь 55.22 байна.

## 2.2. Судалгааны арга зүй

Хүүхдийн интернет донтолтыг Кимберли ян боловсруулан “интернет донтолт бий эсэхийг үнэлэх” асуулгыг цахим хэлбэрийн асуулга бэлтгэн мэдээлэл цуглуулсан. Интернет дон бий эсэхийг үнэлэх (IAT) асуулга нь нийт 20 асуултаас бүрдэх ба насанд хүрэгчид болон өсвөр насны хүүхдэд зориулагдсан тест юм. 1с- 5 хүртэлх шкалаар үнэлнэ (1-хэзээ ч үгүй, 2-цөөн, 3-дундаж, 4-олон удаа, 5-байнга), ингэхдээ 20-49 оноог “интернет хэрэглээ ердийн” түвшинд, 50- 79 оноо “интернет хэтрүүлэн хэрэглэдэг”, 80-100 оноо “интернетийн хамаарал тод” илэрч байна гэж үзнэ. Харин судалгааны үл хамаарах хувьсагч буюу эцэг эхийн хүүхдийн хүмүүжлийн арга барилийг хэмжихдээ “Parenting style questionnaire” нийт 30 асуулттай аргаар хэмжсэн. “parenting style questionnaire” нь дотроо 3 үндсэн

эцэг эхийн хүмүүжлийн арга барилд хуваагдана. 1-рт Хайрлах, хүндэтгэх хэв маяг (Authoritative), 2-рт Үл хайхрах (lack of control), 3-рт Захирангуй хэв маяг (authoritarian) гэсэн гурван үндсэн хэсэгт хуваагдсан.

## Судалгааны үр дүн, боловсруулалт:

Судалгааны үр дүнг IBM SPSS Statistics 25 программаар descriptive statistics, crosstabs, хувьсагчуудын хоорондын хамаарал, регрессийн шулуун, хоёр түүврийн т шинжилгээ ашиглан боловсруулсан.

Зураг 1. Судалгааны асуулгын найдварт чанар  
 IAT интернет донтолтын асуулга  
 Parenting style questionnaire Эцэг эхийн хүмүүжлийн арга барилыг  
 хэмжих асуулга

<b>Cronbach's Alpha</b>	0.902	0.786
-------------------------	-------	-------

*Хүснэгт 1. Судалгаанд оролцогчдын давтамж болон эзлэх хувь*

	Давтамж	Эзлэх хувь
<b>Хүйс</b>		
Эмэгтэй	127	64.8%
Эрэгтэй	68	34.7%
<b>Ангийн түвшин</b>		
9-р анги	20	10.2%
10-р анги	65	33.2%
11-р анги	68	34.7%
12-р анги	42	21.4%

Нийт судалгаанд оролцогчдын хэрэглэдэг түвшний хамгийн олон интернет донтолтыг нийт ангийн давтамжтай нь 11-р ангийн түвшний үзүүлэлт 111 (N=195) суралцагчид байна. (Хүснэгт 2-т суралцагч буюу 56.9% нь интернетийн хэрэглээ аль түвшинд “интернет хэтрүүлэн хэрэглэдэг” их илэрч байна тэр үзүүлэлтээр (50-79 оноо). Интернет хэтрүүлэн гаргасан болно.

*Хүснэгт 2. “Интернет хэтрүүлэн ашигладаг” ангийн сурагчдын үзүүлэлт*

	Давтамж	Эзлэх хувь
<b>9-р анги</b>	9	8.1%
<b>10-р анги</b>	36	32.4%
<b>11-р анги</b>	42	37.8%
<b>12-р анги</b>	24	21.6%

*Хүснэгт 3. Эцэг эхийн хүмүүжлийн арга барил, интернетийн донтолтын хоорондын хамаарал*

	ИНТЕРНЕТ ХҮМҮҮЖЛИЙН НИЙЛБЭР	ДОНТОЛТЫН ЭЦЭГ ЭХИЙН АРГА БАРИЛ
Пирсоны корреляци	0.330**	0.330**
Sig (2-tailed)	<.001	<.001

Тайлбар: Пирсоны корреляцийг эцэг дээр ач холбогдолтой  $<.001$ , эхийн хүмүүжлийн арга барил, хамаарал нь  $0.330^{**}$  сул хамааралтай интернет донтолтын хооронд ч ач холбогдлын хувьд өндөр шинжилгээ хийж үзэхэд sig утга  $0.01$  үзүүлэлт гарч ирсэн.

*Хүснэгт 4. Эцэг эхийн хүмүүжлийн арга барил тус бүрийг нийт интернет донтолын хоорондын хамаарал нөлөөний зэрэг*

	R (square)	B утга	Sig (p) утга
Хайрлах, хүндэтгэх арга барил	0.012	0.008	0.910
Захирангуй арга барил	0.222	0.491	$<.001$
Үл хайхрах арга барил	0.117	1.051	$<.001$

*Тайлбар:* Хамаарлын ач холбогдол дээр тулгуурлан эцэг эхийн арга барилыг хооронд нь харьцуулж, регрессийн шинжилгээ хийж үзэхэд  $r$  ( $0.524$ ),  $R$  (sq)  $0.275$  эцэг эхийн хүүхдээ хүмүүжүүлэх арга барил нь интернет донтолтод  $27.5\%$ -иар нөлөөлдөг, өөрөөр хэлбэл интернет донтолтод дангаараа эцэг эхийн арга барил дээрх хувиар нөлөө үзүүлдэг байна. Харин аль хүмүүжлийн арга барил хүүхдийн интернетэд донтоход хүргэж байгаад шинжилгээ хийж үзэхэд үл хайхрах болон захирангуй хэлбэрээр хүүхэдтэйгээ харьцдаг хүүхдийн интернет донтох магадлал хайрлах, хүндэтгэх хэлбэрээр харьцдаг эцэг эхтэй харьцуулбал өндөр нөлөөг үзүүлж байна. (Хүснэгт 4-с үзүүлэлтийг харна уу) судалгааны үр дүнгээс харвал хүүхэдтэйгээ захирангуй, үл хайхрах байдлаар харьцдаг нь ач холбогдлын түвшинд өндөр  $<.001$ , ( $23.278+0.491^{*}$ захирангуй арга

барил+ $1.051^{*}$ үл хайхрах арга барил). Энэ нь захирангуй болон үл хайхрах арга барил  $0.491$ ,  $1.051$  нэмэгдэх тусам хүүхдийн интернетэд донтох байдал ихэсч байгааг харуулж байна.

## ДҮГНЭЛТ

Судалгааны үр дүнгээс харахад эцэг эхийн хүмүүжлийн арга барил нь хүүхдийн дэлгэцийн донтолтын түвшинд шууд нөлөөлдөг болох нь тогтоогдсон. Захирангуй (authoritarian) болон үл хайхрах (neglectful) хэв маягтай эцэг эхчүүдийн хүүхдүүдийн дунд дэлгэцийн донтолтын түвшин өндөр байхад, хайрлах, хүндэтгэх (authoritative) арга барил нь статистикийн хувьд ач холбогдолгүй үзүүлэлт гарч ирсэн.

Захирангуй арга барилтай эцэг эхчүүд хүүхдэдээ өндөр шаардлага тавьж, тайлбаргүйгээр

үгэндээ орохыг шаарддаг. Энэ нь хүүхдийн өөрийгөө илэрхийлэх чадварыг бууруулж, стресс, дарамтыг нэмэгдүүлдэг. Үүний улмаас хүүхдүүд цахим орчинд хялбархан тайвшрал, хүлээн зөвшөөрлийг хайх магадлалтай болдог. Харин үл хайхрах арга барилтай эцэг эхчүүд хүүхдийн хэрэгцээ, сэтгэл хөдлөлийг үл тоомсорлодог. Энэ нь хүүхдийн өөрийгөө үнэлэх үнэлэмжийг бууруулж, ганцаардал, сэтгэл санааны хоосролыг бий болгож, цахим орчинд донтох үндэс болдог. Тэгвэл хайрлах, хүндэтгэх арга барил нь хүүхдийн зан төлөв, сэтгэл зүйн эрүүл мэндэд эерэг нөлөөтэй байдаг. Хайрлах, хүндэтгэх арга барилтай эцэг эхчүүдийн хүүхдүүд интернет хэрэглээгээ хянах, тэнцвэртэй байх чадвартай болдогтой холбоотой байж болох юм.

### НОМ ЗҮЙ

1. Di, Z., Gong, X., Shi, J., Ahmed, H. O. A., & Nandi, A. K. (2019). Internet addiction disorder detection of Chinese college students using several personality questionnaire data and support vector machine. *Addictive Behaviors Reports*, 10, 100200. <https://doi.org/10.1016/j.abrep.2019.100200>
2. Li, X., Ding, Y., Bai, X., & Liu, L. (2022). Associations between parental mediation and adolescents' internet addiction: The role of parent-child relationship and adolescents' grades. *Frontiers in Psychology*, 13. <https://doi.org/10.3389/fpsyg.2022.1061631>
3. Nannatt, A., Tariang, N. M., Gowda, M., & Devassy, S. M. (2022). Family factors

associated with problematic use of the internet in children: A scoping review. *Indian Journal of Psychological Medicine*, 44(4), 341–348.

<https://doi.org/10.1177/02537176221090862>

4. Pedersen, N. L., & Reynolds, C. A. (1998). Stability and change in adult personality: Genetic and environmental components. *European Journal of Personality*, 12(5), 365–386. [https://doi.org/10.1002/\(sici\)1099-0984\(199809\)12:5%3C365::aid-per335%3E3.0.co;2-n](https://doi.org/10.1002/(sici)1099-0984(199809)12:5%3C365::aid-per335%3E3.0.co;2-n)
5. Sung Ah Chung, Bae, S., Hee Jin Kim, Lee, J.-W., Hwang, H., & Doug Hyun Han. (2023). Mediating effects of attention problems on the link between parenting style and internet gaming disorder in adolescents. *Frontiers in Psychiatry*, 14. <https://doi.org/10.3389/fpsyg.2023.1211889>
6. Enough is Enough. (2013). The dangers of internet use in children and teens: A call for action. Retrieved from <https://enough.org>
7. Bandura, A. (1977). *Social learning theory*. Prentice Hall.
8. Baumrind, D. (1967). Child care practices anteceding three patterns of preschool behavior. *Genetic Psychology Monographs*, 75(1), 43–88.
9. Baumrind, D. (1991). The influence of parenting style on adolescent competence and substance use. *The Journal of Early Adolescence*, 11(1), 56–95. <https://doi.org/10.1177/0272431691111004>
10. Bowen, M. (1966). The use of family theory in clinical practice. *Comprehensive Psychiatry*, 7(5), 345–374. [https://doi.org/10.1016/S0010-440X\(66\)80065-2](https://doi.org/10.1016/S0010-440X(66)80065-2)
11. Di, Z., Gong, X., Shi, J., Ahmed, H. O. A., & Nandi, A. K. (2019). Internet addiction disorder detection of Chinese college students using several personality questionnaire data and support vector machine. *Addictive Behaviors Reports*, 10, 100200. <https://doi.org/10.1016/j.abrep.2019.100200>

12. Jessor, R. (1991). Risk behavior in adolescence: A psychosocial framework for understanding and action. *Journal of Adolescent Health, 12*(8), 597–605. [https://doi.org/10.1016/1054-139x\(91\)90007-k](https://doi.org/10.1016/1054-139x(91)90007-k)
13. Ko, C. H., Yen, J. Y., Yen, C. F., Chen, C. C., & Chen, S. H. (2005). Gender differences and related factors affecting online gaming addiction among Taiwanese adolescents. *The Journal of Nervous and Mental Disease, 193*(4), 273–277. <https://doi.org/10.1097/01.nmd.0000158373.85150.57>
14. Li, X., Ding, Y., Bai, X., & Liu, L. (2022). Associations between parental mediation and adolescents' internet addiction: The role of parent-child relationship and adolescents' grades. *Frontiers in Psychology, 13*. <https://doi.org/10.3389/fpsyg.2022.1061631>
15. Maccoby, E. E., & Martin, J. A. (1983). Socialization in the context of the family: Parent-child interaction. In P. H. Mussen & E. M. Hetherington (Eds.), *Handbook of child psychology: Vol. 4. Socialization, personality, and social development* (pp. 1–101). Wiley.
16. Sung Ah Chung, Bae, S., Hee Jin Kim, Lee, J.-W., Hwang, H., & Doug Hyun Han. (2023). Mediating effects of attention problems on the link between parenting style and internet gaming disorder in adolescents. *Frontiers in Psychiatry, 14*. <https://doi.org/10.3389/fpsy.2023.12118>